



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Дүүргийн архивын дэргэдэх Баримт бичиг  
нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн,  
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Дүүргийн архивын үлгэрчилсэн дүрмийг батлах тухай А/451 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2016 оны Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны үлгэрчилсэн жагсаалт батлах тухай А/832 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Комиссын дарга

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга  
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга  
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга  
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга  
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Мэдээлэл, аюулгүй байдал хариуцсан офицер  
Нийслэлийн Архивын газрын дүүрэг хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга

Архивын тасгийн дарга

2. Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/566 дугаар захирамж, 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/204 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА

1130200659